



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/420

Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/343 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх "Дундговь аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн барилгын сантехникийн засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр "Ган-Илч" ХХК-ийг сонгон 68,000,000 (жаран найман сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу "Дундговь аймгийн Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн барилгын сантехникийн засвар" ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Ган-Илч" ХХК-ний гүйцэтгэх захирал (О.Ганхуяг)-т үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Эрдмийн далай цогцолбор сургуулийн захирал (Т.Туяамандах) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010350

